


## Сүү тараг хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт үнэлгээ хийсэн Тайлан

Аймгийн “Сүү тараг” хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад 2022 оны 9 сарын 15-аас 2022 оны 10 сарын 20-ны хооронд хяналт үнэлгээ хийж ажиллалаа. “Сүү тараг” хөтөлбөр хэрэгжиж байгаа бүх сумдын ЗДТГ-ын дарга нарт аймгийн ЗДТГ-ын НБХэлтэс, аймгийн ЭМГ-с хамтран ажиллах тухай албан тоотыг 2022 оны 9 сарын 13-нд сумдад хүргүүлсэн. Явуулсан албан тоотын дагуу 15 сумаас ирүүлсэн мэдээллийг судалж анализ хийлээ.



ОМОНГОЛЫН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГАЙН ТАМГЫН ГАЗАР

2022 09 11 № 05/239  
СЭМ 10

Хамтран ажиллах тухай

2022 онд “Сүү тараг” хөтөлбөрт хамрагдах бага насны 6-12 сартай хүүхэд 2 хуртай насны нөср хүүхдүүд, 12 хуртай насны хүүхдийн хөгжлийн баримтлалтай хүүхэд, хөнгөн алдагдалтай өсөлтийн хоцрогдолтой, эмзэг бүлгийн хүүхдүүдийг идэвхтэй камруулах, үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэн, удирдлага өргө зүйгээр дэмжин амжилгаж байгаа билээ.


Хөтөлбөрийг 9, 10 дугаар саруудад хэрэгжүүлэхтэй холбоотойгоор шаардлагатай номалт санхүүжилтийг “Сүү тараг” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас шийдвэрлэсэн.

Иймд аймгийн Засаг даргын 2022 оны А/1208 дугаар захирамжаар баталсан нэмэлт санхүүжилтийн хуваарийн дагуу нэгжлэг болон тооцооны баримт ирүүлэн санхүүжилтээ авч хөтөлбөрөө үргэлжлүүлэн хэрэгжүүлж, хамтран амжилгаж уу.

Хавсралтаар аймгийн Засаг даргын А/1208 дугаар захирамжийг хүргүүлэв.

НИЙГМИЙН БОДЛОГЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА Ц.БАДАМЦЭРЭН

Утас: 77099002-70-44-7-000  
4622072179



МОНГОЛ УЛС  
ОМОНГОЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАЙН  
ХЭЛТЭЭС

2022 09 11 № 05/239

Сүү тараг хөтөлбөрийг хэрэгжүүлэн  
санхүүжилт олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 86 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төргүүлэгчдийн 2021 оны 89 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны А/7 дугаар тогтоолын тавдугаар хавсралтын 4 дэх заалт, Ойноговь аймгийн 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний 4 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь.

1. “Сүү тараг” хөтөлбөрийг 2022 оны 8 дугаар сар хуртал хэрэгжүүлэхэд сум орон нутгийн шаардлагатай зарлагыг хавсралтаар баталсуугаа.

2. Сум орон нутгийн хэмжээнд хөтөлбөрт хамрагдах хүүхдүүдэд сүү сүүн бутлагдлуун нийлүүлэх аж ахуйн нэгжийг Төвийн болон орон нутгийн өмчийн иргэдийн төрөлжүүлэн үйлдвэрлэх үйлдвэрлэлтэй хамтран ажиллах тухай зууламтай хамтран ажиллах тухай тогтоомжийг үүрэгний зохион байгуулалт, санхүүжилтийг гүйцэтгэх тухай зууламтай хамтран ажиллах тухай захирамжаар хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас зарцуулахыг Санхүү тэргийн сэлгэйн хэлтэс (Б.Очиргалт)-т зөвшөөрсүгэй.

3. Хөтөлбөрийн хэрэгжүүлэхэд сумд шаардлагатай 153 672 000 (нэг зуун таван гурван сая зургаан зуун далан хоёр мянган зөврийг) Засаг дарга дансны амжилгажүүлж буйд нэмж зөвшөөрсөн “Сүү тараг” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас зарцуулахыг Санхүү тэргийн сэлгэйн хэлтэс (Б.Очиргалт)-т зөвшөөрсүгэй.

4. Хөтөлбөрийг амжилгаж хэрэгжүүлэх үр дүнтэй хэрэгжүүлж, удирдлага зохион байгуулалтаар хөгжих хэрэгжүүлэхэд хөтөлбөр хэрэгжүүлж, үр дүнтэй хэрэгжүүлэн үйлдвэрлэл бүр тайлангаж амжилгаж Орчин мөнхийн газар (Г.Шинэтуяа)-г, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж удирдлага өргө зүйгээр хөгжин амжилгаж Нийгмийн бодлогын хэлтэс (Ц.Бадамцэрэн)-т тус тус үргэлж болгохтай.

ЗАСАГ ДАРГА СЭДДОРЖ

4622012877

Эрүүл мэндийн газартай 4 удаагийн уулзалт хийж, ажиллах төлөвлөгөө гарган хөтөлбөрийн мэргэжилтэн Одмаатай хамтран ажиллалаа. Аймгийн төвийн 3 өрхийн хамрагдсан байдлыг өрх болон ханган нийлүүлэгч дээр очиж ажиллаж, баруун бүсээс Хүрмэн Баяндалай, зүүн бүсээс Цогтцэций, Цогт-Овоо, Ханхонгор суманд газар дээр очиж хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт үнэлгээ хийсэн.







Аймгийн төв Даланзадгад сумын сүү таргаг хөтөлбөрийг хэрэгжүүлэгч, ханган нийлүүлэгч “Сүүн дэвжих” ХХК дээр хүүхдэд сүү таргаг олголтын байдлыг хянаж 9 сарын 26-наас 7 хоногийн турш ажлын зураг авалт хийж, сүү таргаа авахаар ирсэн эцэг эхчүүдтэй ярилцлага хийж, сэтгэл ханамжийн судалгаа авлаа.







**22 оны 10 сарын 3-нд Хүрмэн сумын Засаг дарга Ганболд, ЗДТГ-ын дарга Хүрэлбаатар, ханган нийлүүлэгч “Хахилга 4 бэрх ХХК Алтантулга, сумын эрүүл мэндийн төвийн дарга Туул, хөтөлбөр хариуцсан эмч Насанцэцэг, хөтөлбөрт хамрагдаж байгаа эцэг эхийн төлөөлөлүүдтэй уулзаж сэтгэл ханамжийн судалгаа авлаа.**





**2022-10-04-нд Баяндалай сумын ЗДТГ-ын дарга Энхбаяр, Эрүүл мэндийн төв Олонбаяр, Мягмарсүрэн нартай уулзаж холбогдох материалуудтай танилцаж, ярилцлага хийж, хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүдийн эцэг эхээс сэтгэл ханамжийн судалгаа авлаа.**



**Цогтцэций 2022-10-12 Эрүүл мэндийн төвийн хөтөлбөр хариуцсан эмч Ганбат, эмнэлгийн мэргэжилтнүүдтэй уулзаж эрүүл мэндийн төв дээр ажиллаа.**



**Цогт-Овоо 2022-10-18-нд Нийгмийн ажилтан Амаржаргал, хөтөлбөр хариуцсан эмч Бямбацэрэн, хөдөлмөр халамж үйлчилгээний мэргэжилтэн Түвшинзул, нягтлан бодогч Мөнхоргил нартай уулзаж сумын ЗДТГ, эмнэлэг дээр ажиллаж эцэг эхчүүдээс сэтгэл ханамжийн судалгаа авлаа.**






## Хөтөлбөрийн 1-р зорилтын хүрээнд

### 1.1 Сумдад ажлын хэсэг байгуулсан эсэх, үйл ажиллагааны төлөвлөгөө, журам, ханган нийлүүлэгчтэй хийсэн гэрээ, түүний үр дүнд дүн шинжилгээ хийх

Баяндалай, Булган, Цогт-Овоо, Гурвантэс, Мандал-овоо, Цогтцэций сумдад ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсэг “Сүү тараг” хөтөлбөрийн хярэгжилтэнд хяналт тавьж ажилладаг. Бусад сумдад ажлын хэсэг байгуулагдаагүй байна.





Бүх сумд гэрээ байгуулсан байна. Гэрээнд зарим суманд сумын Эрүүл мэндийн төв хамтран гарын үсэг зурсан, ихэнх сумд Сумын ЗДТГ, ханган нийлүүлэгчийн хооронд гэрээ байгуулсан байна.

Эрүүл мэндийн газарт ирүүлсэн ханган нийлүүлэгч талуудын мэдээллийг судлан 6 суманд газар дээр нь ажиллаж, Булган, Гурвантэс, Сэврэй, Манлай, Ноён, сумын ханган нийлүүлэгчтэй утсаар холбогдож тодруулга мэдээлэл авсан.

### Сүү тараг хөтөлбөрийн ханган нийлүүлэгчтэй гэрээ байгуулсан байдал

№	Сумын нэр	Гэрээ байгуулсан талууд	Гэрээний хэрэгжилт
1	Баяндалай	ЗДТГ, Эмнэлэг, ханган нийлүүлэгч	Гэрээнд ажлын хэсгийн, ханган нийлүүлэгчийн, эмнэлгийн үүргийг тусгасан, сүүний үнийг тогтвортой барихаар заасан
2	Баян-Овоо	Ханган нийлүүлэгч, эмнэлэг, сумын ЗДТГ	Гэрээний заалтууд ерөнхий байна
3	Булган	Ажлын хэсэг, эмнэлэг, ханган нийлүүлэгч	Гэрээний заалт ерөнхий
4	Гурвантэс	Эмнэлэг, ханган нийлүүлэгч	Гэрээнд ажлын хэсэг, эмнэлэг, ханган нийлүүлэгчийн үүрэг тусгасан, сүү тарагны үнэ тогтоосон
5	Мандал-Овоо	Эмнэлэг, ханган нийлүүлэгч	Гэрээнд ажлын хэсэг, нийлүүлэгч, эмнэлгийн үүргийг тусгасан, сүү тарагны үнэ тогтоосон
6	Номгон	ЗДТГ, ханган нийлүүлэгч	талуудын эрх үүргийг заагаагүй, ерөнхий өөр гэрээний загвартай Санхүүжилтийг урьдчилгаа 100 олгохоор заасан
7	Цогт-Овоо	Ажлын хэсэг, эмнэлэг, ханган нийлүүлэгч	Гэрээний заалт ерөнхий
8	Цогтцэций	ЗДТГ, эмнэлэг, ханган нийлүүлэгч	Ажлын хэсэг, эмнэлэг, ханган нийлүүлэгчийн үүргийг тусгасан, сүү тарагны үнэ тогтоосон
9	Ханбогд	ЗДТГ, нийлүүлэгч	Талуудын үүрэг тусгаагүй, ажлын гэрээ байдлаар гэрээ хийсэн
10	Ханхонгор	ЗДТГ, эмнэлэг, ханган нийлүүлэгч	Гэрээний заалт ерөнхий
11	Хүрмэн	ЗДТГ, ханган нийлүүлэгч	Гэрээний заалт А тал, Б талын эрх үүрэг хэт ерөнхий
12	Даланзадгад	Захиалагч, нийлүүлэгч	Өрх тус бүрийн хамрагдах хүүхдийн тоонд хамааруулж ажлын гэрээний маягтаар хийсэн, талуудын эрх үүрэг тодорхойгүй, өрхийн эмнэлгийн үүрэг огт тусгаагүй

**Баяндалай, Гурвантэс, Даланзадгад, Мандал-Овоо, Манлай, Ноён, Цогт-Овоо, Цогтцэций сумдын ханган нийлүүлэгч нар үхэр, ямааны сүү, тараг нийлүүлж**



эмнэлэг нь хүүхдүүдийн эцэг эхэд сүү тараг олгодог байна. Бусад сумдын гэрээт ханган нийлүүлэгч нь гоё, дээж, гэр тараг, өглөө, сайн, цэвэр, дээж сүү өгч байсан байна. Сэврэй сумын эмнэлэг ханган нийлүүлэгчээс 7 хоног бүр хүүхдийнхээ тоогоор захиалгаа өгч маш хариуцлагатай ажиллаж байсан байна. Харин зарим суманд тухайлбал Хүрмэн, Ханхонгор суманд дэлгүүрээс нь эцэг эхчүүдэд сүү таргаа шууд өгдөг, хэдий хэмжээтэй ямар бүтээгдхүүн өгсөн нь тодорхойгүй байсан. Мөн сүү тараг олголтын дэвтэр дэлгүүр дээр байлаа. Манлай сумын Хайрхан дэлгүүр 9,10 сард дан ганц цэвэр сүүг эцэг эхчүүдэд сард 1 удаа бөөнөөр нь өгсөн гэсэн мэдээлэлтэй байна.


Аймгийн төв Даланзадгад сумын сүү тараг хөтөлбөрийг хэрэгжүүлэгч, ханган нийлүүлэгч “Сүүн дэвжих” ХХК нь 2022 оны 06 сараас 10 сарын 25 дуустал гэрээтэй ажиллаж байгаа. Аймгийн төвийн 3 өрхийн эмнэлгийн хамрагдах хүүхдүүдийн нэрсийн авч хуваарийн дагуу компани дээрээ сүү тараг олголт хийдэг. Эцэг эхчүүд нь сүү тараг олголтын дэвтэрээ авчирч тэмдэглэгээ хийлгэдэг.



3 өрхийн эмнэлэгтэй хийсэн гэрээг үзлээ. Даланзадгад сумын ЗДТГ, ханган нийлүүлэгчийн гэрээнд зарим заалт бүрхэг байна. Гэрээнд 2 талын үүргийг сайн тусгаж өгөөгүй тухайлбал өрхийн эмнэлэг хүүхдээ бүрэн хамруулах, зар өгөх, хамрагдаж байгаа эсэхийг тогтмол хянах, явцад нь яаж авч байгааг үзэх, сав суулга ямар байх ёстой стандарт эрүүл мэнд талаас сургалт сурталчилгаа явуулах зэрэг харилцан холбоотой ажиллах заалтууд ороогүй байна. Гэрээнд өрхийн эмнэлгийн үүрэг ролийг тодорхой тусгаагүй тул эмнэлэг талаасаа анхаарал хандуулах ажил дутмаг байлаа. Даланзадгад сумын ЗДТГ, ханган нийлүүлэгч Сүүн дэвжих компани хооронд гэрээ хийсэн хэн нэгэн хүн тодорхой хяналт тавьдаггүй, санхүүжилт нь



сумаас шууд хийгддэг учраас эмнэлэг оролцоо муу зөвхөн хүүхдийнхээ нэрийг өгдөг хяналтгүй, ханган нийлүүлэгч шууд сүү тараг олгодог байдалтай байна.







Хүрмэн сумын ЗДТГазар сүү тараг ханган нийлүүлэгчтэй хийсэн гэрээ, санхүүжилтийн баримтыг үзлээ. Ажлын хэсэг байгуулаагүй байна. Өмнө нь эмзэг бүлгийн хүнсний таланоор хүнсний бараа өгч сайн ажиллаж байсан учраас энэ компанийг сонгож гэрээ хийсэн.









**Баяндалай сум 2 айлтай гэрээ хийсэн. Үхэртэй айл Буянхүү, Одгэрэл гэсэн 2 малчин айл байгаа. Үхрийн тараг, сүүгээ эмнэлэг дээр хүлээн авч олголтыг эмнэлэг хийдэг.**

**Цогцэций сумын ЗДТГ, Эмнэлэг, ханган нийлүүлэгч гэсэн гурвалсан гэрээ хийсэн. Сүү тараг нийлүүлэгч нэхэмжлэхээр эмнэлэгт өгдөг, сүү тараг олголтыг хийж, эмнэлэг баримтаа бүрдүүлж сумын ЗДТГазарт өгдөг.**

**Цог-Овоо сум 6 сарын 5-нд сүү тараг хөтөлбөрийн нээлтээ хийж, 6 сартайгаас 1 настай хүүхдийн хоололтын талаар сургалт явуулж, хоолны үзэсгэлэн гаргасан. Эхний 4.5 сард сүү тараг гараагүй байсан тул "Бадрахбилэг" компанитай гэрээ байгуулсан дээж сүү, тараг өгдөг байсан. 6 сараас эхлэн малчинтай гэрээ байгуулсан.**





Эмнэлэг дээр сүү таргийг хүүхдэдээ тарааж байгаа нь хариуцлагатай, хүүхдүүдийн хамрагдалт эцэг эхчүүдэд шаардлага тавих, хүүхдээ хянахад сайн талтай байлаа.

**Цогт-Овоо сум** 4,5 сард сүү тараг гараагүй байсан тул компанитай гэрээ байгуулж сүү тараг өгсөн. Эмчийн хүсэлтээр 6 сараас эхлээд хөдөөний малчинтай гэрээ байгуулж сүү тараг нийлүүлсэн. Хамрагдах хүүхдүүдийн нэрсийг эмнэлэг сар бүр гаргаж өгдөг. Эцэг эхчүүд сэтгэл ханамжтай байгаа

**2 Зорилтот бүлгийн хамрагдвал зохих хүүхдүүдийн, хамрагдалт, Сүү тараг олголт, шилжилт хөдөлгөөн, эрүүл мэндийн үзлэгийн мэдээний талаар мэдээлэл цуглуулах, газар дээр нь үзэх дүн шинжилгээ хийх**

№	Сумын нэр	Хамрагдвал зохих хүүхэд	Хамрагдсан хүүхэд	Хувь	Зөрүү
1	Даланзадгад	2149	2549	118%	+400
2	Баяндалай	152	152	100%	0
3	Баян-Овоо	211	211	100%	0
4	Булган	97	125	128%	+28
5	Гурвантэс	340	212	62,3%	-128
6	Мандал-Овоо	116	116	100%	0
7	Манлай	244	138	55,5%	-106
8	Номгон	157	136	86,6%	-21
9	Ноён	128	172	134%	+44
10	Сэврэй	154	113	73,3%	-41
11	Цогт-Овоо	149	185	124%	+36
12	Цогтцэций	762	210	27,5%	-552
13	Ханбогд	533	547	102%	+14
14	Ханхонгор	90	86	95,5%	-4
15	Хүрмэн	83	62	74,6%	-21

**Хүрмэн сумын эмнэлэг** дэвтэр олголт хийсэн, дэвтэр дээр анхны хэмжилт хийсэн, эцэг эхчүүд дэлгүүрээс сүү тарагаа авдаг. Эмнэлэг төдийлөн холбогдоогүй. Дэвтэр дээр 2 дах хэмжилт хийснийг бичээгүй, үзлэгийн хуудас дээр хэмжилтүүдээ хийсэн гэж үзүүлээ.

**Баяндалай сум** 4 сард 31, 5 сард 31, 6 сард 33, 7сард 29, 8 сард 28, 9 сард 14 хүүхэд хамрагдсан. Одоо 10 сард 18 хүүхэд хамрагдаад эхэлсэн. Одоо 6-12 сартай 11, ХБ 3 байгаа 10 сараас 6 сартай ихэр хүүхэд нэмэгдсэн.

**Үйлчлүүлэгч ээж :** Дэвтэр эмнэлэг дээр байх зүгээр байдаг. Сүү тараг маш сайхан амттай, хүүхэд маань амтархан иддэг.

**Эмч Олонбаяр:** Сүүний чиглэлийн үхэртэй 2 малчин айлаас сүүгээ авдаг. Долоо хоногийн 1,4 дэр өдөр олголтоо хийдэг. 10 сараас зогсохгүй үргэлжлэх боломжтой. Өвөл хаврын улиралд хоол тэжээлийн дутагдалтай байдаг тул үргэлжлүүлэх саналтай байна. Утсаар эцэг эхчүүдэд мэдэгдэж тараалт хийдэг, утасны зардал бас



гарнаа.Өсөлт хөгжил хоцрогдолтой хүүхдийг төв хөдөө гэхгүйгээр заавал хамруулах шаардлагатай. Энэ жил наадмын урт өдрүүдэд аялаж яваад сүү тарагаа авахгүй алга болсон. Сүүг нь хөлдөөж таргийг нь хамаатанд нь өгсөн.

**Эмч Мягмарцэрэн:** Хүүхэд 6 сараас 1 настайдаа төдийлөн хоолонд сайн ороогүй байдаг. Ялангуяа сүү уухад зохихгүй эхийн сүүгээр голдуу байдаг. Иймд 1 наснаас 3 насны хүүхдийг хамруулахад хамгийн зүгээр санагддаг. Энэ хөтөлбөр маш хэрэгтэй хөтөлбөр. Хөдөөний хүүхдийн хамаргдалт муу байгаа ирж авч чаддаггүй. Ийм тохиолдолд амин хүчил, дархлаажуулалтын бүтээгдхүүн өгөх нь дээр байх. Манай сум сүүний чиглэлийн үхэртэй 2 айлтай болохоор өвөл, хавар ч үргэлжлүүлэх боломжтой.

**Хүрмэн сум Насанцэцэг:** Алслагдсан хөдөөний хүүхдүүд хамрагдаж чадахгүй байгаа, зарим эцэг эхчүүд өгсөн зүйлийг голно.Эцэг эхчүүд хяналтанд хүүхдээ авчирч үзүүлдэггүй. Дэлгүүрээс эцэг эх сүү тарагаа яаж авч байгааг хянаагүй,сүү тарагны үнэ өссөн. Зарим хүмүүс бэлэн мөнгийг нь авмаар байна гэсэн саналтай байдаг. Сүү тараг хөтөлбөр өмөн нь хэрэгжихдээ эмнэлэг гэрээг нь хийж , эмнэлэг дээр сүүг хөөрүүлж, тараг бүрж хүүхдүүдэд олгодог байсан.

**Сэврэй эмч Алтансүх:** Сумын төвийн хүүхдүүд бүрэн хамрагдсан, хөдөөнөөс цөөн хүүхэд хамрагдсан. Холын хүүхдүүд ирж авах боломжгүй байдаг. Энэ төсөл хүүхдүүдэд маш хэрэгтэй хэдэн ихрүүд хүртэл хөөрхөн болсон. Дан сүү тараг байх уу эсвэл ээдэм, бяслаг гэх мэт бүтээгдхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, дархлаажуулалт, витаминжуулалт хэрэгтэй. Хонгорын гол дээр сувилалын нээлтээ хийсэн. Баруун сумд гандуу байгаа болохоор голдуу дэлгүүрээс гоё тараг авдаг. Улаанбаатарт 1 хүүхэд тохирсон пакеттай байдаг. Гэхдээ орон нутгийн малчидаа мөн дэмжиж тэднээс сүү тарагаа авсан дээр.

Ган гачигдтай үед хүүхдийн тэжээл байвал зүгээр санагдсан. Манайх 7 хоногт 1,4 гэсэн 2 өдөр тараалтаа хийдэг. Анх өдөр бүр өгөх гэж үзсэн боломжгүй санагдсан.

**Цогтцэций сумын** эрүүл мэндийн төв сүү тараг хөтөлбөр 5 сарын 14-нөөс эхэлсэн. 7 хоногийн 3 дах өдөр сүү тарагаа авч тараалт хийдэг. Сард 160 орчим хүүхэд хамрагдахаас хамгийн их нь 80 хүүхэд хамрагдах боломжтой тоо гарсан. 40 хүүхэд тасралтгүй хамрагдаж байгаа. Сүүгээ эхлээд 80 хүүхдээр гэрээ хийгээд авсан. Зарим нь ирэхгүй байсан тул хасаж дан тараг өгдөг болсон. 5,6,7,8,9 сард дан тараг өгсөн. 10 сарын эхний 7 хоног тараг өгсөн. Дан ямааны сүүний тараг өгч байсан одоо ямааны сүү татраад өгөх боломжгүй болсон. 1 удаад 1л тараг өгдөг, заримдаа 2 л тараг өгдөг гэх боловч хэмжээг нь тавиагүй нотлох баримтгүй байна. Хүүхэд 1 нас хүрсэн ч хасалт хийдэггүй сүү тарагаа өгсөөр байсан.

**Ганбат эмч:** Дунд нь хэмжилт хийнэ гэж тооцоогүй учраас хэмжилт хийгдээгүй байна. \Программд байхгүй\ Дэвтэр дээр өдөр бүр гарын үсэг зурахаар хийгдсэн тул өдөр бүр гэдгээр гарын үсэг зуруулдаг. 1 удаад хэдийг өгдгийг тэмдэглээгүй. Цаашид дэвтрийн хэвлэлтэнд анхаарах



**Цогт-Овоо сум эмнэлэг дээр сүү нийлүүлэлтээ хийж эмнэлэг сүү тараг олголтоо хийдэг. Сард 2 удаа олгодог. Сүү тараг олголтын дэвтэр эмнэлэг дээр байна. 10 сард 17 хүүхэд хамрагдана. 9 сард 21 хүүхэд хамрагдсан. Сүү 1 л 5000 төгрөг, 8 сараас 1л 6000 төгрөгний үнэтэй болсон. Ямааны сүү өтгөрсөн тул сүүний үнийг нэмсэн. Ямааны сүүний тараг маш өтгөн чанартай сайн тараг байсан. 2 дах хэмжилтээ хийсэн. Дэвтэр дээр сүү тараг алиныг нь өгснийг тэмдэглэсэн гэхдээ нэг удаад хэдийг өгснийг тэмдэглээгүй. 1 удаадаа тогтмол 1л өгч байсан, 9 сард 1 удаа 2л өгсөн.**

**Цогт-Овоо ХХУ-ний мэргэжилтэн Түвшинзул:** Сүү тараг хөтөлбөрийн хавтастай. Ажлын хэсэг байгуулсан. Дэлгүүрүүдэд хамтран ажиллах санал явуулаад сонгож 4,5 сард гэрээ байгуулсан. Ажлын хэсэг гэрээ, санхүүгийн баримт бүрдүүлэлт, тайлангаа хугацаанд нь өгөх дээр анхаардаг. Мөн эцэг эхчүүдэд баталгаат савандаа сүү тараг авахыг шаарддаг. Хамрагдах хүүхдүүдийн нэрсийг эмнэлэг сар бүр гаргаж өгдөг. Эцэг эхчүүд сэтгэл ханамжтай байгаа

**Хөтөлбөрийн 2-р зорилтын хүрээнд:**

**2.1 Сүү тараг ханган нийлүүлж байгаа иргэн аж ахуйн нэгжийн сүү сүүн бүтээгдхүүн нийлүүлэлтийн аюулгүй байдал, ханган нийлүүлэгч иргэн аж ахуй нэгжийн санхүүжилт, сүү тараг олголтын тэмдэглэл, бүртгэлжүүлэлт, сүү сүүн бүтээгдхүүний нэр төрөл, үнийн тогтвортой байдалд хяналт үнэлгээ хийх**

“Сүү дэгжих говь” стандарт эрүүл ахуйн шаардлагын хувьд түгээгч, цехийн ажилтан эрүүл мэндийн дэвтрээ бөглүүлсэн, сүү тарагны дээжээс сорьцын шинжилгээ өгсөн байна.

Цогт-Овоо сумын сүү тараг ханган нийлүүлэгч малчин эрүүл мэндийн дэвтэртэй болохыг шаардаад дэвтэртэй болсон, шинжилгээ өгсөн



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН  
МАЛ ЭМНЭЛГИЙН  
ЛАБОРАТОРИ**



**ШИНЖИЛГЭЭНИЙ ДУНГИЙН ХУУДАС**

Бүртгэлийн дугаар: 22-256	Хуульч ажилтан Шинжилгээч ажилтан Шинжилгээч дугаарын Бичигч ажилтан	2022 он 10 сард 03 өдөр 2022 он 10 сард 04 өдөр 2022 он 10 сард 04 өдөр 2022 он 10 сард 04 өдөр
---------------------------	---	--

Ашигласан үнэм: Санхүүжилт зөвшөөрлийн тусламжийн лаборатори  
Тайлагч/архивч/нэр: Архивч/нэр  
Дэвтэрийн үнэм: 2  
Дугаар/нэр/хувийн үнэм/үржлийн үнэм/Сурталчилгаа, Өмнөговь - Дэлгэрэнгүй - 8-р багц, Цогт-Овоо сум  
Малчин/нэр:  
Шинжилгээний үнэм/архивч/нэр/дэвтэр/хуудас:  
24 материал/архивч/нэр/хуудас/хуудас

Дэвтэр/хуудас/нэр	Шинжилгээний үнэм/архивч/нэр	Тайлагч/архивч/нэр	Хяналтын үнэм/архивч/нэр	Шинжилгээний үнэм/архивч/нэр
Урхайн Амьс	MNS 4238-2011	Урхайн Амьс	Урхайн Амьс	Урхайн Амьс
Урхайн Амьс	MNS 4238-2011	Урхайн Амьс	Урхайн Амьс	Урхайн Амьс
Урхайн Амьс	MNS 4238-2011	Урхайн Амьс	Урхайн Амьс	Урхайн Амьс
Урхайн Амьс	MNS 4238-2011	Урхайн Амьс	Урхайн Амьс	Урхайн Амьс
Урхайн Амьс	MNS 4238-2011	Урхайн Амьс	Урхайн Амьс	Урхайн Амьс

Шинжилгээний үнэм/архивч/нэр/дэвтэр/хуудас: МНС 4238-2011 стандарт Цогт-Овоо сумын сүүний тарагны үнэм, МНС 0001-1975 стандарт 1 дүг. Байсан. Урхайн Амьс МНС 4238-2011 стандарт Цогт-Овоо сумын сүүний тарагны үнэм, МНС 0001-1975 стандарт 1 дүг. Байсан. Урхайн Сүү МНС 0001-1975 стандарт 207 Байсан. МНС 4238-2011 стандарт 207


**БАТАЛГАА**      **ГҮВЭНТЭГЭЭНИЙ**

ТЭМЦЭГ      **ГҮВЭНТЭГЭЭНИЙ**

Малчин/нэр:  
1. Шинжилгээний үнэм/архивч/нэр/дэвтэр/хуудас/хуудас  
2. Шинжилгээний үнэм/архивч/нэр/дэвтэр/хуудас/хуудас  
3. Шинжилгээний үнэм/архивч/нэр/дэвтэр/хуудас/хуудас

Малчин/нэр/дэвтэр/хуудас/хуудас/хуудас







### Сүү тараг олголтын мэдээлэл

№	Сумын нэр	Хамрагдсан хүүхэд	Олгодог давтамж	Бүт-н төрөл	Өгдөг хэмжээ	Сардаа Нийлүүлсэн хэмжээ	Өртөг
1	Баяндалай	152	7 хоногт 2 удаа	Сүү тараг	7 хоногт 2 л	130л 1 удаа 240л 3 удаа 110л1 удаа	Сүү 3000 Тараг 3500
2	Баян-Овоо	211	7 хоногт 1 удаа	дээж сүү, дээж тараг	7 хоногт 1л	Тараг 2л Сүү 3л	Тараг5000 Сүү 4700
3	Булган	125	Сард 2 удаа	Гоё тараг Өглөө сүү	1,4 л тараг 1,4 л сүү	343,5л тараг 343,5 л сүү	Тараг 4,300 Сүү 4,300
4	Гурвантэс	212	7 хоногт 2 удаа	Сүү тараг	Сүү 3л Тараг2л	Сүү 631 л Тараг 424 л	Сүү 4000 Тараг 6000
5	ДЗ	2549	Сард 4 удаа	Сүү тараг	Тараг 3л Сүү 2,4л		
6	МО	116	Сард 1 удаа	Гоё тараг Өглөө сүү Аарц, сүү тараг	Сүү 4л Тараг 2л аарц0,5г тараг 1л сүү 2л	Гоё 200 л Өглөө100л Аарц 11 кг Сүү132л Тараг114 л	Гоё 5000 Өглөө4000 Тараг сүү 4000-6000
7	Манлай	138	Сард 2 удаа	Үхрийн сүү	Сүү 2л Тараг 2 л	Сүү 561,4 л Ямааны сүү 91,6л	Цэвэр сүү 4000
8	Ноён	172	Сард 6 удаа	Гоё, Ямаа, үхрийн сүү тараг	Тараг 4л Сүү 2л	тараг 688 л сүү 440л	Гоё 5500 Сүү 5000- 7000
9	Номгон	136			5,300 л		
10	Сэврэй	113	Сард 4 удаа	Өглөө сүү Гоё тараг	Сүү 3л Тараг 2,5 л	Тараг 304,6 л Сүү 323,2л	1 удаад 6000
11	Цогт-Овоо	185	Сард 1- 2 удаа	Ямааны сүү, тараг	Сүү 1л Тараг 1л	Тараг 114 л Сүү 204 л	Сүү 5000 Тараг 6000
12	Цогтцэций	210	Сард 4 удаа	тараг	Тараг 1л	Тараг 992л	Тараг 4000
13	Ханхонгор	86	Сард 4 удаа	Сайн, гоё, дээж тараг Сайн сүү	Сүү 2л Тараг 2л		Сүү 5000 Тараг 6000
14	Ханбогд	547	Сард 2 удаа	Дээж 2ш Bifido 900 Сайн D 4 ш маамуу 2ш	Сардаа 4,4л		Bifido 5500 Дээж 4600 Сайн D1400 Маамуу сүү1850
15	Хүрмэн						

#### Даланзадгад “Сүүн дэвжих” компани нэг өдрийн ажлын зураг авалт

1 дэх өдөр 100 орчим хүүхэд сүү тараг авахаас 4 дэхээ авсан 22 хүүхэд, өнөөдөр биднийг очиход 10 гаруй хүүхэд сүү таргаа авсан байсан. 6 сартай хүүхэд сүү тарагаа авахаар ирсэн. 9 сарын 9-д өрх дээр очоод сүү тараг авахаа мэдсэн гээд анх удаа сүү тараг авахаар ирсэн. 2л хэмжээтэй нэг савтай ирсэн. Энэ хүүхдэд 9 сарын 4 удаагийн олголт 3л орчим сүү, 2,4л тараг өгнө гэсэн. 2л таргаа бөөнөөр нь аваад, сүүгээ эргэж авахаар явсан. Сүү тараг олголтын хөтөлгөө



дээр 9 сарын 4 удаагийн авалтыг 4 удаагаар тэмдэглэсэн, хөтөлгөөний дэвтэр дээр мөн 4 удаагаар тэмдэглэсэн.

"Сүү-тараг" хөтөлбөр | 2021-2022

"Сүү-тараг" хөтөлбөрт хамрагдсан хүүхдийн асран хамгаалагчийн мэдээлэл

УРГИЙН ОВОГ Твин  
 ОВОГ НЭР Руржесар Бамсид  
 ХУИС 21  
 АЙМАГ Өвч  
 СУМ ЗБ  
 БАГ Т  
 ГЭРИЙН ХАЯГ ГЭС-32

РЕГИСТРИЙН ДУГААР КН90093061  
 ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДАХ ДАНСНЫ ДУГААР \_\_\_\_\_

КАРТ ХҮЛЭЭЖ АВСАН ХҮНИЙ НЭР П. Бамсид  
 ХӨТӨЛБӨР БАРИХ УТАСНЫ ДУГААР 8060355  
80329677

Урсгийн өдөр Савд  
 Ойролцоо нэр Авсгал  
 Хүүхдийн нэр Бугдан  
 Хүйс Э  
 Аймаг Өвч  
 Суу ЗБ  
 Баг Т  
 Гэрийн хаяг ГЭС-32

Эрүүл мэндийн даатгалын дэвтэрийн дугаар \_\_\_\_\_  
 Рамзитрийн дугаар \_\_\_\_\_  
 Хөтөлбөрт хамрагдаж эхэлсэн өдөр 2021 оны 9 сар  
 Хөтөлбөрт хамрагдаж дууссан өдөр 2022 оны 12 сар

Дэвтэр нээсэн хүний албан тушаал С/г  
 Гэрийн үсэг С/г

"Сүү-тараг" хөтөлбөр | 2021-2022

Сүү тараг хөтөлбөрт хамрагдсан хүүхдийн анхан шатны үзлэгийн хуудас

Үзлэг хийсэн 20.02 оны 6 сарын 30нд

Толгойн тойрог 01 Цус багдалтын шинж +/- \_\_\_\_\_  
 Хооллолт:  Сайн  Хооллолтын бэрхшээлтэй

Рахитын шинж тэмдэг Шүдний тоо 2 Илэрсэн / Илрээгүй \_\_\_\_\_  
 Хавийн  Хавийн бус юм уу өвчтэй

Ерөнхий эрүүл мэндийн байдал:  Эрүүл  Тогтмол хяналт шаардлагатай

Эрүүл мэндийн байгууллага Эмчийн нэр Сүхбаатар

Хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжил ба хооллолтын талаар тэмдэглэл

Суралтын нас / саргаар	Үзлэг хийсэн 01 сар өдөр	Хямажилт / Тоог бичээд дараа нь өсөлтийн үзүүлэлтүүд дээр цэгээр тэмдэглэнэ			Жегилийн алдагдал			Бусад		
		Жин (кг)	Урт өндөр (см)	БХИ (г/м2)	Хавийн	2SD	3SD	Сүүлцан	АЗЛХалаа ар	Бусад
<u>3</u>	<u>21</u> / <u>30</u> 9.0	<u>67</u>							<u>+</u>	

Эргий тэмдэглэл Б.С. Бамсид

6 сард сүү тараг олгогдсон байдал

1 Гарын үсэг	2 Гарын үсэг	3 Гарын үсэг	4 Гарын үсэг	5 Гарын үсэг	6 Гарын үсэг
8 Гарын үсэг	9 Гарын үсэг	10 Гарын үсэг	11 Гарын үсэг	12 Гарын үсэг	13 Гарын үсэг
15 Гарын үсэг	16 Гарын үсэг	17 Гарын үсэг	18 Гарын үсэг	19 Гарын үсэг	20 Гарын үсэг
22 Гарын үсэг	23 Гарын үсэг	24 Гарын үсэг	25 Гарын үсэг	26 Гарын үсэг	

\*Сүү тараг олгосон хүний гарын үсэг

БИЛЭГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ПАРТИЙН ТАМГЫН ГАЗАР



"Сүү-тараг" хөтөлбөр | 2021-2024 он

7 сард сүү, тараг олгогдсон байдал

1* Гарын үсэг	2 Гарын үсэг	3 Гарын үсэг	4 Гарын үсэг	5 Гарын үсэг	6 Гарын үсэг	7 Гарын үсэг
8 Гарын үсэг	9 Гарын үсэг	10 Гарын үсэг	11 Гарын үсэг	12 Гарын үсэг	13 Гарын үсэг	14 Гарын үсэг
15 Гарын үсэг	16 Гарын үсэг	17 Гарын үсэг	18 Гарын үсэг	19 Гарын үсэг	20 Гарын үсэг	21 Гарын үсэг
22 Гарын үсэг	23 Гарын үсэг	24 Гарын үсэг	25 Гарын үсэг	26 Гарын үсэг		

\*Сүү тараг олгосон хүний гарын үсэг

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

"Сүү-тараг" хөтөлбөр | 2021-2024 он

8 сард сүү, тараг олгогдсон байдал

1* Гарын үсэг	2 Гарын үсэг	3 Гарын үсэг	4 Гарын үсэг	5 Гарын үсэг	6 Гарын үсэг	7 Гарын үсэг
8 Гарын үсэг	9 Гарын үсэг	10 Гарын үсэг	11 Гарын үсэг	12 Гарын үсэг	13 Гарын үсэг	14 Гарын үсэг
15 Гарын үсэг	16 Гарын үсэг	17 Гарын үсэг	18 Гарын үсэг	19 Гарын үсэг	20 Гарын үсэг	21 Гарын үсэг
22 Гарын үсэг	23 Гарын үсэг	24 Гарын үсэг	25 Гарын үсэг	26 Гарын үсэг		

\*Сүү тараг олгосон хүний гарын үсэг

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

"Сүү-тараг" хөтөлбөр | 2021-2024 он

Сүү тараг хөтөлбөрт хамрагдсан хүүхдийн хоёр дахь шатны  
уялзгийн хуудас

Талаг хийсэн \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ сарын \_\_\_\_\_ нд

Төлгөөн тооног см	Цус багадаагүй индекс +/-	Хооллолт: <input type="checkbox"/> Сайн <input type="checkbox"/> Хэвгэлтэйгээр баршралтай
Рактын шинж тэмдэг: Илэрсэн / Илрээгүй	Шүдний тос <input type="checkbox"/> Амны мэндийн байдал	
	<input type="checkbox"/> Хэвийн <input type="checkbox"/> Хэвийн бус ком уу өөрчлөлтэй	
Ерөнхий эрүүл мэндийн байдал:		
<input type="checkbox"/> Эрүүл <input type="checkbox"/> Тогтмол хяналт шаардлагатай		
Эрүүл мэндийн байгууллага _____		
Энгийн нэр _____		

Хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжилт ба хооллолтын талаар тэмдэглэл


Хүнний нэр / Талаг хийсэн өдөр	Хэмжээ / Тоог бичээд дараа нь өсөлтийн үзүүлэлтүүд дээр цагаар тэмдэглэнэ			Жингийн алдагдал		Өвчлөл			
	Жин кг	Ур, өндөр см	BMI кг/м2	Хэвийн	2SD	3SD	Сүүрвэг	АЗВ/Харьс	Бусад

\_\_\_\_\_ / Боловсрол, хөгжилд гарч буй өөрчлөлт /

\*Сүү тараг олгосон хүний гарын үсэг

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР





**Энхтуяа:** Манай сүүний хувьд цөцгийг нь авдаггүй тараг хийж өгдөг давуу талтай. Сүү ямар ч хольцгүй шууд сааж авчраад л буцалгаж хэрэглэдэг. 1,2 өдөр "Шим билэг", 3 дах өдөр "Өнө орших", 4,5 дах өдөр "Энхийн Хүслэн" өрхийн эмнэлгийн хүүхдүүд сүү таргаа авдаг. Эхний 2 өдөр "Шим билэг" авдаг их замбараагүй, 1,2 дах өдрийн сүү тараг авалт дандаа холилдож ирдэг. Сардаа багтаж ирвэл 4 удаагийн олголтыг өгдөг, сар дамнаж ирвэл өмнөх сарыг олгодоггүй. Хүүхдийнхээ сүү таргийг голдуу эмээ нар ирж авдаг. Холоос сүү таргаа авдаг хүүхдийн эцэг эх голдуу 4 удаагаа бөөндөж авдаг. Зориулалтын савгүй янз бүрийн сав барьж ирдэг. Сүү тараг авах сав цэвэр байх, таглаатай байх тал дээр анхаарахаар байдаг. Эхний 6 сард 7 хоногт өгнө гэдгийг хатуу барьсан их сүү гашилгаж байгууллага алдагдалд орж байсан.

Цех нь төвөөс зайдуу, төвд түгээлт хийх цэг гаргаж сүү тараг олголтыг ойртуулах шаардлагатай юм байна. Цехийн тохижолт дажгүй сайн байсан ЖДҮ-с зээл авч байраа засварлаж тоног төхөөрөмж авсан. Нутгийнхаа фермерүүдийг дэмжсэн сайн ажил болж байгаа. ЭМГ-с Сүү тараг хөтөлбөрийн том хаяг өгсөн гадаагаа хадаагүй байна.

Энэ жил ган гачигтай үхэр бэлчээрт явахгүй эрт тэжээх төлөвтэй өвсний фондоос өвч тэжээл авч баймаар байна.

7 хоногт 1 удаа сардаа 4 удаа сүү тараг олгодог боловч зарим эцэг эхчүүд 2 долоо хоногт 1 удаа, сардаа 1 удаа сүү тарагаа бөөн авч байгаа нь яг хүүхдэдээ хэрхэн хүрч байгаа нь эргэлзээтэй байлаа.



Хүрмэн сумын сүү тараг ханган нийлүүлэгч “Хахилга 4 бэрх” компани дээр сумын төвөөс 10 хүүхдийн сүү тараг олголтын дэвтэр байсныг үзлээ. Хөдөөний 7 хүүхэд байгаа. Сүү тараг олголтын дэвтэр ханган нийлүүлэгч дээр байдаг, ямар хэмжээтэй ямар бүтээндхүүн олгосон нь дэвтэрт тэмдэглэгдээгүй гар утсан дээр зарим нэг хүний зураг авсан байна. Тухайлбал:

Г. Мөнхсүвд 5,6 сар бүтэн, 7 сард 1 удаа

У.Азбаяр 5,6,7 сар бүтэн авсан

Б.Анхдөлгөөн 5 сард 3 удаа, 6 сард 3 удаа

Г.Мөнх-Оргил 6 сард 3 удаа авсан ба сүү тараг олголтын дэвтэрт өдрүүдийг бүхэлд нь гарын үсэг зурсан.

Э.Батсуурь, Х.Бархүү, Б.Баатарчулуун гэсэн хүүхдүүд 1 ч удаа сүү тараг аваагүй, хөдөөнөөс ирэхээр нь бөөн өгнө гээд байж байсан.

### Сүү тараг хөтөлбөрийн санхүүжилтийн байдал

№	Сумын нэр	Нийт авсан санхүүжилт	Зарцуулсан санхүүжилт	Үлдэгдэл	Батлагдсан санхүүжилт
1	Баяндалай	3,648,000	3,295,000	353,000	3,648,000
2	Баян-Овоо	5,064,000	5,064,000	0	5,064,000
3	Булган	3,261,000	3,000,000	261,000	2,328,000
4	Гурвантэс	8,160,000	6,600,000	1,560,000	8,160,000
5	Даланзадгад	76,488,000	61,190,000	15,297,000	76,488,000
6	Мандал-Овоо	2,784,000	2,784,000	0	2,784,000
7	Ноён	4,128,000	4,128,000	0	3,072,000
8	Номгон	3,768,000	3,768,000	0	3,768,000
9	Сэврэй	3,696,000	2,712,000	925,500	3,696,000
10	Манлай	5,856,000	3,311,800	2,544,200	2,784,000
11	Цогт-Овоо	3,576,000	1,704,000	1,872,000	3,576,000
12	Цогтцэций	18,288,000	3,968,000	14,320,000	18,288,000
13	Ханбогд	18,528,000	13,128,000	5,400,000	12,792,000
14	Ханхонгор	3,264,000	2,064,000	1,200,000	2,160,000
15	Хүрмэн	1,992,000	1,612,000	380,000	1,992,000
	Нийт дүн		118,328,000	44,112,700	153,672,000

Цогтцэцийд үлдэгдэл санхүүжилт өндөр байгаа. Хүүхдийн шүдний үзлэг хийхэд зориулах санал тавьсан ЭМГ-с ч дэмжих хандлагатай байсан. ЗДТГ компанид шилжүүлэг хийдэг, эмнэлэг нэхэмжлэх хүүхдийн нэрсийн жагсаалт өгдөг. 9 сарын нэхэмжлэхтэй хамт сүү тараг авсан гэсэн хүснэгтэнд эцэг эхийн гарын үсэг зуруулж өгсөн. Үлдэгдэл санхүүжилтийг яаж зарцуулах талаар чиглэл өгөх хэрэгтэй байна





ЭРХЭМ ДЭГ 1

№	Төрөл	Хэмжээ	Тайлбар	Төлөө	Төлөө
1	Хонь	100			
2	Хонь	200			
3	Хонь	300			
4	Хонь	400			
5	Хонь	500			
6	Хонь	600			
7	Хонь	700			
8	Хонь	800			
9	Хонь	900			
10	Хонь	1000			
11	Хонь	1100			
12	Хонь	1200			
13	Хонь	1300			
14	Хонь	1400			
15	Хонь	1500			
16	Хонь	1600			
17	Хонь	1700			
18	Хонь	1800			
19	Хонь	1900			
20	Хонь	2000			

ЭРХЭМ ДЭГ 2

№	Төрөл	Хэмжээ	Тайлбар	Төлөө	Төлөө
1	Хонь	100			
2	Хонь	200			
3	Хонь	300			
4	Хонь	400			
5	Хонь	500			
6	Хонь	600			
7	Хонь	700			
8	Хонь	800			
9	Хонь	900			
10	Хонь	1000			
11	Хонь	1100			
12	Хонь	1200			
13	Хонь	1300			
14	Хонь	1400			
15	Хонь	1500			
16	Хонь	1600			
17	Хонь	1700			
18	Хонь	1800			
19	Хонь	1900			
20	Хонь	2000			

ЭРХЭМ ДЭГ 3

№	Төрөл	Хэмжээ	Тайлбар	Төлөө	Төлөө
1	Хонь	100			
2	Хонь	200			
3	Хонь	300			
4	Хонь	400			
5	Хонь	500			
6	Хонь	600			
7	Хонь	700			
8	Хонь	800			
9	Хонь	900			
10	Хонь	1000			
11	Хонь	1100			
12	Хонь	1200			
13	Хонь	1300			
14	Хонь	1400			
15	Хонь	1500			
16	Хонь	1600			
17	Хонь	1700			
18	Хонь	1800			
19	Хонь	1900			
20	Хонь	2000			

ЭРХЭМ ДЭГ 4

№	Төрөл	Хэмжээ	Тайлбар	Төлөө	Төлөө
1	Хонь	100			
2	Хонь	200			
3	Хонь	300			
4	Хонь	400			
5	Хонь	500			
6	Хонь	600			
7	Хонь	700			
8	Хонь	800			
9	Хонь	900			
10	Хонь	1000			
11	Хонь	1100			
12	Хонь	1200			
13	Хонь	1300			
14	Хонь	1400			
15	Хонь	1500			
16	Хонь	1600			
17	Хонь	1700			
18	Хонь	1800			
19	Хонь	1900			
20	Хонь	2000			

**Ганбат:** Эцэг эхчүүд сүү тарагаа ав гэж олон удаа яриулдаг. Өөрсдийн утсаар ярьдаг болохоор утасны төлбөр их гардаг. Үлдэгдэл санхүүжилтээ хэрхэн зарцуулах талаар чиглэл авах хүсэлтэй байна. 2023 онд нарийн судалгаатай тооцоотойгоор сүү тараг хөтөлбөрөө хэрэгжүүлнээ. 2021 оны 11 сард 2-3 сар



явагдаад хаагдсан. Уурхайчдын хүүхдүүд 14 хоног суманд 14 хоног хотод байдаг. Хяналтанд баригддаггүй. Вакцин хийлгэхдээ л ирдэг.

### **Хөтөлбөрийн 3-р зорилтын хүрээнд:**

#### **3.1 Эцэг эхчүүдэд зөв хоололт, бага насны хоол тэжээл, нэмэгдэл хоол, амин дэм, асаргаа сувилгааны талаар сургалт сурталчилгаа хэрхэн хийсэн.**

Цогт-Овоо сум сүү тараг хөтөлбөрийн нээлтийн өдөр 6 сартайгаас 12 сартай хүүхэд ямар хоол идэх талаар хоолны үзэсгэлэн гаргаж сургалт хийсэн. Бусад сумд сургалт төдийлөн хийгээгүй байна.

8 сумын эрүүл мэндийн төв болон аймгийн “Бумбардай” зуны сувилал ихэр, жингийн алдагдалтай, хоол тэжээлийн дутагдалтай хүүхдүүдэд элс нараар чийрэгжүүлэх, айраг, шар сүү, хар цай, ясны шөл, сүүнд оруулж, витаминжуулалт, тохирсон хоол, тосон бариа зэрэг эмчилгээ асаргаа хийж ажилласан.

“Бумбардай” зуны сувилалд “Энхийн хүслэн” өрхийн эмнэлгээс 15, “Шим билэг” өрхийн эмнэлгээс 17, “Өнө орших” өрхийн эмнэлгээс 19 нийт 51 хүүхэд хамрагдсан байна. Сувилалын 10 хоногт ЭМГ-с батлагдсан хоолны зэсний дагуу хүүхэд эцэг эхчүүдэд өдөр бүр хоол өгч, “Бага насны хүүхдийн хоололт”, “Хүүхдийн асаргаа”-ны талаар сургалт явуулсан байна.

Зуны сувилалд Баян-Овоо сум 30 хүүхэд, Ханбогд сум 17 хүүхэд, Ноён сум 24, Цогт-Овоо сум давхардсан тоогоор 130, Манлай сум 28, Хүрмэн сум 15, Цогтцэций сум 31 хүүхэд нийт 173 хүүхдийг зуны сувилалд хамруулсан байна.

**Цогт-Овоо ХХҮ-ний мэргэжилтэн Түвшинзул:** Сүү тарагаа яг хүүхдэдээ зориулж хэрэглэж байгаа эсэх нь бүрхэг, сүүнээс илүү тараг хэрэгтэй. Сүү тараг өгөхийн зэрэгцээ дархлаажуулалт, сэргээн засах тоног төхөөрөмжтэй болох нь чухал байна. Цэцэрлэг витаминжуулалт хийдэг, эмнэлэг А, Д амин дэм үнэгүй өгдөг. Хөгжлийн бэрхшээлтэй 9 хүүхэд байдаг, сэргээн засах тоног төхөөрөмж хэрэгтэй. Сүү тараг авсан айлд очиход сүүгээр нь цайгаа сүлээд ууж байгаа, манай хүүхэд тараг иддэггүй юмаа гээд өгөхгүй байгаа тохиолдол ч байсан. Сүү тараг хөтөлбөр энэ байдлаар хэрэгжвэл үр дүнгүй иймд сэргээн засах тоног төхөөрөмж авсан дээр юм.

#### **3.2 Сүү тараг хөтөлбөрт хамрагдсан эцэг эхчүүдээс түүврийн аргаар асуумжаар сэтгэл ханамжийн судалгаа авч дүн шинжилгээ хийх**

Сэтгэл ханамжийн судалгаанд бүгд 158 хүн хамрагдснаас Даланзадгад сумын 124, Баяндалай 8, Хүрмэн 5, Цогтовоо 8, Цогтцэций 13 хүн тус тус хамрагдлаа.

Зорилтот бүлгийн хүүхдүүдээс 6-12 сартай хүүхэд 53 / 33.5% /, 2 хүртлэх насны ихэр хүүхэд 6 / 3.7% /, 12 хүртлэх насны хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 13 / 8.2% /, өсөлт хоцрогдолтой, жингийн алдагдалтай хүүхэд 7 / 4.4% / байлаа. Хүүхдэд сүү тараг олгосон хөтөлгөөг дэвтэрт нь тогтмол тэмдэглэсэн 95 / 60.1% / хүүхэд байсан бол тэмдэглэл хийлгээгүй хүүхэд 63 / 39.9% / байжээ.



Сүү тараг авахад тулгамдсан асуудал байдаг эсэхийг судлахад ажлын цаг таардаггүй гэж 12, хуваарьт өдрөө авч чаддаггүй гэж 13 хүн хариулсан байлаа. Бусад 133 хүн ямар ч асуудалгүй гэжээ.

Сүү тараг авч хэрэглэснээс хойш хүүхдэд ямар өөрчлөлт гарч байгааг судлахад 82 /51.8 % / хүүхэд хоолондоо дуртай болсон, сүү цагаан идээнд дуртай болсон, 24/15.1% /дархлаа муудах шинж тэмдэг арилсан, 15/9.5 % сэрэглэн цовоо болсон тус тус хариулсан байлаа.

Хөтөлбөрт хамрагдсан эцэг эхчүүдээс 25/15.8 %/ нь хоол тэжээл, эрүүл мэндийн сургалтанд хамрагдсан бол 133 /84.2 % / нь хамрагдаагүй байна.

Маш сайхан хөтөлбөр байгаа тул цаашид хөтөлбөрийг үргэлжлүүлэх хүсэлтээ бүгд илэрхийлсэн байлаа.

Судалгаанд хамрагдсан эцэг эхчдээс хүүхдээ 2 нас хүртэл хамрагдах, сүү тараг олголтын давтамжийг ойртуулах, эмнэлгээс цаг хугацаанд нь мэдээлэл өгдөг, сургалт хийдэг, хөтөлбөрийг суурин газарт өвөл хавар үргэлжлүүлэх саналууд гаргасан байлаа.







**Сүү тараг хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн үнэлгээ дүгнэлт:**

**Сайн талууд:**

1. Сүү тараг хөтөлбөрт нийт хамрагдсан хүмүүс сэтгэл ханамж их сайн үнэлгээтэй цаашид үргэлжлүүлэх санал хүсэлт их байгаа. Аймгийн төвийн судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдээс аймгийн удирдлагуудад баярлаж талархснаа илэрхийлсэн байлаа.
2. Хамрагдсан хүүхдүүдийн биед эерэг өөрчлөлт гарч байгаа. Хоолонд дуртай болсон ялангуяа тараг сүү цагаан идээнд дуртай болсон . Биеийн дархлаа сайжирч байгаа. цовоо сэргэлэн болсон гэж олон хүн илэрхийлсэн
3. Сүү хөтөлбөр таргийг цаашид хэрэгжүүлэх нь хүүхдийн эрүүл мэнд өсөлт хөгжилтөнд их ач холбогдолтой байна. Эцэг эхчүүдийн сэтгэл ханамж өндөр байгаа.
4. **Баяндалай, Гурвантэс, Даланзадгад, Мандал-Овоо, Манлай, Ноён, Цогт-Овоо, Цогтцэций** сумдын ханган нийлүүлэгч нар үхэр, ямааны сүү, тараг нийлүүлж малын гаралтай бүтээгдхүүнээр хангаж байна.
5. **Баяндалай, Цогтцэций, Цогт-Овоо, Сэврэй, Ноён, Ханбогд, сумын ханган нийлүүлэгчид** эмнэлэг дээр сүү таргаа авчирч нэхэмлэхээр өгдөг, эмнэлэг сүү тараг олголтыг хийдэг байна. Эмнэлэг дээр сүү таргийг хүүхдэдээ тарааж байгаа нь хариуцлагатай, хүүхдүүдийн хамрагдалт эцэг эхчүүдэд шаардлага тавих, хүүхдээ хянахад сайн талтай байлаа.
6. Малыг сүү тараг хүүхдүүдэдээ өгч байгаа газрын эцэг эхчүүд сэтгэл ханамжтай, ялангуяа хүүхдүүд тараг идэх дуртай гэж ярьж байлаа.
7. Сүү олголтын дэвтэр нь аймгийн төвийн эцэг эхчүүдийн гар дээр байдаг сүү тарагаа аваад тогтмол тэмдэглэгээ хийлгэдэг, дэвтрээ авчираагүй хүнд



үйдлчилдэггүй байсаар эцэг эхчүүд сүү тараг олголтын дэвтрээ авчирч тэмдэглэгээ хийж сурсан.

8. Цогт-Овоо сум сүү тараг хөтөлбөрийн нээлтийн арга хэмжээ зохион байгуулж 6 сартайгаас 12 сартай хүүхэдийг зөв зохистой хооллох талаар сургалт хийж, хоолны үзэсгэлэн гаргасан байна.
9. Баяндалай, Цогт-Овоо, Сэврэй сумын гэрээний заалт тодорхой эмнэлэг, ажлын хэсгийн үүргийг тодорхой заасан сайн талтай байлаа.
10. Баяндалай, Ноён, Сэврэй сумд гэрээндээ сүү тарагны үнийг тогтвортой байхаар тусгасан нь бараа бүтээгдхүүний үнэ өсөхөд ханган шийлүүлэгч сүү тарагнахаа үнийг өсгөхгүйгээр гэрээ хийсэн байна.

**Сул талууд:**

1. Сүү таргаа 7 хоногоор, 2 долоо хоногоор зарим тохиолдолд сардаа 1 удаа олгож байгаа нь зорилтот бүлгийн хүүхдэд хэрхэн хүртэж байгаа нь эргэлзээтэй байлаа.
2. Хөдөө малчин айлын зорилтод бүлгийн хүүхдүүдийг хамрагдахаар оруулсан ч хамрагдаж чаддаггүй.
3. Ханган нийлүүлэгч компани зарим дэлгүүрүүд сүү тараган бүтээгдхүүн нийлж байгаа нь хүүхдэд тохиромжтой байгаа эсэх, хүүхдэдээ хүрч байгаа эсэх нь тодорхойгүй байна. Тухайлбал Хүрмэн, Ханбогд, Булган суманд анхаарал татсан асуудлууд байлаа.
4. Сүү олголтын дэвтэр компани дээр, эмнэлэг дээр байгаа нь эцэг эхчүүдийн хариуцлагыг сулруулсан, сүү тараг олголтын бүртгэлийг бүрхэгдүүлсэн байна.
5. Сүү тараг олголтын дэвтэрт хэдий хэмжээтэй бүтээгдхүүн олгож байгаагаа тэмдэглэдэггүй, 1 удаад олгож байгаа сүү тараг олголтын хэмжээг тавьсан газар байгаагүй.
6. Зөвхөн ЗДТГ, ханган нийлүүлэгч хооронд гэрээ хийсэн эмнэлгийн талаас үүрэг хариуцлагыг тусгаагүй, ажлын даалгавар байдлаар гэрээ хийсэн нь талуудын оролцоог нарийн гаргаагүй байдалтай байлаа. Тухайлбал Даланзадгад, Номгон, Хүрмэн
7. Эрүүл мэндийн төвүүд хамрагдвал зохих хүүхдүүддээ цаг хугацаанд нь мэдэгдэж зарлах, хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүдийн асран хамгаалагч нарт сургалт хийх, хамрагдсан хүүхдүүдийн эрүүл мэндэд хяналт тавих жин хэмжээ үзэх, сүү тараг хөтөлбөрийн хэрэгжилтийн тухай олон нийтэд мэдээлэх зэрэг үйл ажиллагаа хангалтгүй байгаа нь судалгаагаар гарлаа.
8. Сумын ЗДТГ-аар шууд санхүүжилт хийгдэж байгаа нь эмнэлэг ханган нийлүүлэгчтэй төдийлөн хамтраж ажиллах боломжгүй байна. Иймд нийлээд сумын эмнэлэг санхүүжилтийг эмнэлгээр дамжуулах саналтай байна.
9. Сүү олгох дэвтэрт өдөр бүр тэмдэглэгээ хийхээр хэвлэгдсэн тул 7,14, хоногоор олгож байгаа ч өдөр бүр дээр гарын үсэг зуруулж байгаа нь бодит биш харагдаж байна. Дэвтэрт олгосон он сар өдөр, сүү тарагны хэмжээ тавих хүснэгт, утасны дугаар, онош тавих хүснэгт оруулах саналтай байна



**Сүү тараг хөтөлбөрийн явцын хяналт үнэлгээний дүгнэлт, санал:**

1. Гэрээнд захиалагч гэрээлэгч нарын хамтран ажиллах заалтуудыг нарийн болгох, хариуцлагыг тодорхой тусгах, өрхийн эмнэлэг, сумын эрүүл мэндийн төвийг оролцуулах, үүрэг хариуцлагыг тодорхой болгох, хэрэгжилтэнд хяналт тавих байгууллага хариуцах албан тушаалтныг эрх үүргийг оруулах, талууд гэрээний хэрэгжилтийн явцын талаар сар бүр ярилцлага хийж асуудлаа ярилцаж байх ингэснээр ажлын уялдаа холбоо сайжирч хөтөлбөрийн үр дүнг тооцох боломжтой болно.
2. Дэлгүүрийн сүү тараг өгч байгаа компаниуд бараагаа борлуулах хандлагатай байгаа тул сүү таргийг орлосон бүтээгдхүүн аль болох өгөхгүй байх. Малын гаралтай эко бүтээгдхүүнээр хангах талаар илүү анхаарах хэрэгтэй байна.
3. Сүү тараг олголтыг эмнэлэг дээр хийдэг байх, эмч мэргэжилтнүүд хүүхдэдээ анхаарах нь илүү ач холбогдолтой
4. Аймгийн төв болон суурин газарт сүү таргийг өдөр бүр хэмжээгээр нь олгодог байх боломжийг судлах бүрдүүлэх ингэснээр сүү тараг зорилтот бүлгийн хүүхдэдээ бодитоор хүрч үр дүн гарна.
5. Хүүхдийн эрүүл мэнд өсөлт хөгжилтөнд их ач холбогдолтой, эцэг эхчүүдийн сэтгэл ханамж өндөр байгаа тул сүү хөтөлбөр таргийг цаашид хэрэгжүүлэх нь зүйтэй.
6. Хүүхдэд ид хоолонд орж байгаа насанд нь 8,9 сартайгаас эхлээд 2 нас хүртэлх хугацаанд сүү тараг олгох, жин алдагдалтай, өсөлтийн хоцрогдолтой хүүхдэд бяслаг ээдэм зэргийг нэмж олгох боломжийг хайх
7. Хөдөө малчин айлын хүүхдүүд холоос авч чадахгүй байгаа тул сүү тарагны оронд витаминжуулалт хийх, эсвэл сүү тараг хөтөлбөрийг төв суурин газрын хүүхдийг хамруулах гэж заалттай байх
8. Сүү таргийг 7 хоногт 1 удаа, 14 хоногт 1 удаа, заримдаа 1 сараар бөөнтөж өгч байгаа нь хүүхдэд тэжээл болох нь бага, гэр орныхон нь хэрэглэх боломж олгож байгаа тул төв суурин газарт өдөр бүр өгөх боломжийг хайх
9. Даланзадгад сумын ханган нийлүүлэгч сүү таргийн 1 удаагийн өгөлтийн савалгаатай болгох. Одоо борлуулалт хийж байгаа сүүний үйлдвэр нь төвөөс зайтай байгаа тул хүмүүс бөөнтүүлж авах, таксигээр очих хүндрэл байдаг тул төвд сүү түгээх цэг байгуулах
10. Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүд хэдэн хүүхдийн нэр гагаад орхидог, эцэг эхэд нь бүрэн мэдээлэл өгдөггүй, жин хэмжилт, сургалт хийдэггүй асуудал ихэнх газарт байгаа тул хөтөлбөрийн заалтын дагуу хүүхдүүдээ бүрэн хамруулах, хяналт тавих ажлыг эрс сайжруулах шаардлагатай.
11. Зарим сумдад сүү тараг хүүхдэд бүрэн хүрч байгааг мэдэх боломж муу байгаа, тэмдэглэл хөтөлгөө байхгүй, санхүүгийн баримт хангалтгүй байгаа тул ажлын хэсэг ханган нийлүүлэгчийн үйл ажиллагаанд хяналт тавих үүргийг маш сайн болгох заалт оруулах

Тайлан гаргасан:  Д.Мядагсүрэн /Тунамал сэлэнгэ ТББ/